



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 04

Хажуу шинэ ус

Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны салбар чиглэл батлах тухай


Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн 3.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит арвангуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Говь-Угтаал сумын хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны салбар чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Зээл олгохдоо батлагдсан салбар чиглэлийг баримтлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий хороодод үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Булган)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ПҮРЭВСЭНГЭ

4824030004

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын  
иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
2024 оны 4 дугаар сарын 23  
өдрийн 24 тогтоолын хавсралт

ГОВЬ-УГТААЛ СУМЫН ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН  
2024 ОНЫ ЧИГЛЭЛ

Д/д	Салбар чиглэл	
1	Хүнсний үйлдвэр	<ul style="list-style-type: none"><li>- Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл</li><li>- Талх, хариин боов гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл</li><li>- Малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах, худалдаалах</li><li>- Мах махан бүтээгдэхүүн боловсруулах, худалдаалах</li><li>- Хоол үйлдвэрлэл</li></ul>
2	Хөнгөн үйлдвэр	<ul style="list-style-type: none"><li>- Төмөр эдлэл үйлдвэрлэл</li><li>- Оёдол эсгүүр үйлдвэрлэл</li><li>- Гутал үйлдвэрлэл</li><li>- Модон эдлэл/ мужаан, гэрийн тавилга/</li><li>- Сүлжмэл нэхмэл ноосс ноолууран эдлэл</li><li>- Хөг хаягдал ангилан ялгалт, дахин боловсруулах</li><li>- Хэвлэлийн үйлдвэр</li></ul>
3	Газар тариалан	<ul style="list-style-type: none"><li>- Төмс, хүнсний ногоо</li><li>- Мод, Жимс жимсгэнэ тариалах</li><li>- Хүлэмжийн аж ахуй</li><li>- Тэжээлийн ургамал тариалалт</li></ul>
4	Мал аж ахуй	<ul style="list-style-type: none"><li>- Арьс, шир боловсруулах</li><li>- Эсгий эдлэл</li><li>- Мал үржлийн ажил үйлчилгээ</li><li>- Мал эмнэлэгийн ажил үйлчилгээ</li><li>- Гахай, шувууны туслах аж ахуй</li><li>- Эрчимжсэн мал аж ахуй</li></ul>
5	Барилга	<ul style="list-style-type: none"><li>- Блок, тоосго, замын өнгөт хавтан үйлдвэрлэл</li><li>- Зөөврийн сууц, төмөр хашаа, хийц</li></ul>
6	Үйлчилгээ	<ul style="list-style-type: none"><li>- Үсчин гоо сайхан манекюр</li><li>- Авто засвар, дугуй засвар</li><li>- Гагнуур</li><li>- Гутал засварын үйлчилгээ</li><li>- Зочид буудлын үйлчилгээ</li><li>- Аялал жуулчлал</li><li>- Алт мөнгөний дархан</li><li>- Хүн эмнэлэг</li></ul>